

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Хөвсгөл аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn Аудитор: Ц.Чагнаадорж Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorjts@audit.gov.mn Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/300
танай -ны № -т

“ШИНЭ-ИДЭР ДУЛААН ЭРДЭНЭТ”
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Л.БААСАНЖАВ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 35,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч бүртгэлд тусгасан. Мөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглах боломжтой 2,228.5 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, 1,200.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг актлан бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 60,907.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 57,698.2 мянган төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 3,208.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд холбогдох шийдвэрийг гаргуулан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 09/24 дүгээр тогтоолоор “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг тогтоосон ба түүнийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АЭРДЭНЭБААТАР



“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,948,137.70	2,244,351.40
1.1.4	Бусад авлага	18,878,716.56	0.00
1.1.5	Татварын авлага	2,557,246.42	123,178,793.88
1.1.6	Бараа материал	15,814,192.33	18,896,893.83
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	48,198,293.01	144,320,039.12
1.2.1	Үндсэн хөрөнгө	720,663,906.51	687,058,224.37
1.2.2	Биет бус хөрөнгө	16,076,444.44	14,361,166.66
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	736,740,350.96	701,419,391.04
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	784,938,643.97	845,739,430.15
2.1.1.1	Дансны өглөг	55,405,469.50	62,761,724.26
2.1.1.2	Цалингийн өглөг	90.00	0.00
2.1.1.3	Татварын өр	0.00	24,827,302.31
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,809,016.39	43,926,219.69
2.1.1.9	Хойшлогдсон албан татварын өр	486,983.45	486,983.45
2.1.1.12	ХАОАТ өглөг	5,212,547.21	24,021,259.84
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	62,914,106.55	156,023,489.54
2.2	Өр төлбөрийн нийт дүн	62,914,106.55	156,023,489.54
2.3.1	Өмч: - төрийн	838,676,437.96	873,676,437.96
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	207,155,817.14	208,469,317.14
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	24,539,500.00	24,539,500.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(348,347,217.68)	(416,969,314.49)
2.3.10	Тайлант үеийн үр дүн		(68,622,096.81)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	722,024,537.43	689,715,940.61
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	784,938,643.97	845,739,430.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(цэвэр)	482,300,092.64	582,805,294.30
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	415,634,422.80	529,769,523.81
3	Нийт ашиг (алдагдал)	66,665,669.83	53,035,770.49
4	Хүүний орлого	29,585.91	106,223.68
5	Ерөнхий ба удирдлагын зардал	84,643,324.28	120,660,657.51
6	Санхүүгийн зардал	79,100.00	81,699.99
7	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(18,027,168.54)	(67,600,363.33)
8	Орлогын татварын зардал	438,078.28	10,622.37
9	Татварын дараах ашиг (алдагдал)	(17,589,090.26)	(67,610,985.70)
10	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		(1,011,111.11)
11	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(17,589,090.26)	(68,622,096.81)
12	Орлогын нийт дүн	(17,589,090.26)	(68,622,096.81)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Аудитын код: ХӨА-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

**“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(241,214,657.98)	678,157,097.12
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(107,132,559.70)	(107,132,559.70)
Өмчид гарсан өөрчлөлт	151,000,000.00	0.00	0.00	0.00	151,000,000.00
2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	838,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(348,347,217.68)	722,024,537.42
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(68,622,096.81)	(68,622,096.81)
Өмчид гарсан өөрчлөлт	35,000,000.00	1,313,500.00	0.00	0.00	36,313,500.00
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	873,676,437.96	208,469,317.14	24,539,500.00	(416,969,314.49)	689,715,940.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	536,044,535.99	538,203,506.91
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	536,044,535.99	536,886,838.91
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	1,316,668.00
1.2	Мөнгөн зарлага (-)	510,256,929.41	531,201,709.48
	Ажиллагчдад төлсөн	185,969,118.91	222,649,935.30
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	53,658,623.04	22,590,309.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	39,145,700.00	83,802,137.00
	Ашиглалтын зардалд төлсөн	10,273,115.22	83,297,609.69
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	114,503,998.40	109,179,884.60
	Татварын байгууллагад төлсөн	44,741,511.41	5,283,980.60
	Даатгалын төлбөрт төлсөн	133,900.00	262,300.00
	Бусад мөнгөн зарлага	1,830,962.43	4,135,553.29
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,787,606.58	7,001,797.43
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	81,035.00	494,416.27
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	400,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	81,035.60	94,416.27
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,310,800.00	16,200,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,310,800.00	16,200,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(19,249,283.19)	(15,705,583.73)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,557,842.18	(8,703,786.30)
5	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	4,390,295.52	10,948,137.70
	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	10,948,137.70	2,244,351.40

“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйлчилгээний орлого	579,588,028.00	579,733,828	-145,800.02	100
Усны орлого	1,854,540.00	3,071,466.28	-1,216,926.28	166
Хүүгийн орлого		106,224	-106,224	
НИЙТ ДҮН	581,442,568	582,911,518	-1,468,950	100
Цалин	249,396,280.00	244,422,455.00	4,973,825	98
НДШ	36,431,338.00	35,989,084.37	442,254	99
Нүүрс худалдан авах	64,000,000.00	63,988,409.50	11,591	100
Нүүрс тээвэрлэлт	89,500,000.00	87,114,572.25	2,385,428	97
Түлш шатахуун	9,272,727.00	9,211,707.84	61,019	99
Цахилгааны зардал	80,000,000.00	78,455,726.86	1,544,273	98
Хөдөлмөр хамгаалалын зардал	15,674,000.00	13,760,909.58	1,913,090	88
Шуудан холбоо	650,000.00	620,454.55	29,545	95
Бичиг хэрэг	1,633,000.00	773,126.12	859,874	47
Сургалтын зардал	2,000,000.00	1,920,000.00	80,000	96
Томилолт	1,000,000.00	639,700.00	360,300	64
Төлбөр хураамж аудитын зардал	5,000,000.00	4,908,000.00	92,000	98
Засвар үйлчилгээ	9,705,000.00	7,117,229.48	2,587,771	73
ТУЗ-ийн зардал	6,049,885.00	4,725,000.00	1,324,885	78
ТХ Татвар даатгалын зардал	300,000.00	262,300.00	37,700	87
Газар ус ашигласны төлбөр	500,000.00	1,091,117.00	-591,117	218
ЭХЗЗ-ийн үйлчилгээний зардал	2,400,000.00	1,135,553.29	1,264,447	47
ТХ татварын зардал	300,000.00	280,000.00	20,000	93
Тэтгэмж урамшуулал,нийгмийн асуудал	11,500,000.00	8,891,486.68	2,608,513	77
Элэгдэлийн зардал	50,000,000.00	85,123,348.79	-35,123,349	170
ОАТЗардал		10,622.37	-10,622	
Банкны шимтгэл		81,700	-81,700	
НИЙТ ДҮН	635,312,230	650,522,503.67	-15,210,274	102
АШИГ АЛДАГДАЛ	-53,869,662	-67,610,986	13,741,324	126

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,452.0 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 2,800.0 мянган төгрөгийн алдааг залруулж, материаллаг бус 1 албан шаардлага, 10,652.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- 2024 онд хийгдсэн 2 800.0 мянган төгрөгийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" гэсэн заалтууд зөрчигдсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын код: ХӨА-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

- Шилэн дансанд 5 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 7,443.2 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 47 455.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 9 нэр төрлийн 11 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалт зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны нэмж олгох амралтын 5 хоногийг олгоогүй, амралтын мөнгийг ажилласан цалингаар тооцсон, татвараас чөлөөлөх 1 300.8 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тооцон суутгасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйл албан татвараас чөлөөлөх орлого 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", 25 дугаар

**“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

зүйлийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно" гэсэн заалтууд зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын мэдээллийг тулгаж холбогдох хууль тогтоомжийг судлан баримтлан ажиллах

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 1,908 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д "цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингын хүснэгтээрх тооцоолон бодсон цалинг үнэн зөв тайлагнаж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 онд хийгдсэн 2 800.0 мянган төгрөгийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн байна	1	2,800.0			1	2,800.0	1	2,800.0				
Дүн	1	2,800.0			1	2,800.0	1	2,800.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлангийн хугацааны эцэст 7 443.2 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	7,443.2					1	7,443.2				
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 47 455.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 9 нэр төрлийн 11 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-					1	-				

“Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны нэмж олгох амралтын 5 хоногийг олгоогүй, амралтын мөнгийг ажилласан цалингаар тооцсон, татвараас чөлөөлөх 1 300.8 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тооцон суутгасан байна	1	1,300.8					1	1,300.8				
Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 1 908 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна	1	1,908.0					1	1,908.0				
Дүн	4	10,652.0					4	10,652.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 5 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна	-	-	-	-	1	-	-	-
Дүн	-	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Аудитын код: ХӨА-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

